



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2012 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/200

Улаанбаатар хот

Сургалтын төрийн сангаас сургалтын төлбөрийн болон  
амьжиргааны зардлын зээл олгох тухай

Засгийн газрын 2012 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам”, Засгийн газрын 2011 оны 157 дугаар тогтоолоор батлагдсан “Сонгодог урлаг-II” үндэсний хөтөлбөрийн 4.3.6 дахь заалт, Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын 2012 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 1а/1074 дүгээр албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Соёл, спорт, аялал жуулчлалын яамны захиалгаар 2012-2013 оны хичээлийн жилд Австри Улсын Венийн их сургуульд хөгжим судлалын мэргэжлээр суралцах Бат-Амгалан овогтой Санжаажавын сургалтын төлбөр болон амьжиргааны зардлыг Сургалтын төрийн сангийн зээлийн эх үүсвэрээс санхүүжүүлсүгэй.

2. Суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Мөнхцэцэг/, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дээд боловсролын хэлтэс /П.Эрхэмбулган/-т тус тус даалгасугай.



Л.ГАНТӨМӨР

D:\tushaal\STS-2012